МЭДЭЭ · 2019 оны 12-р сарын 31

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН ШИНЭ ОНЫ МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЛЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Мэндчилгээ

Эрхэм хүндэт прокурор, прокурорын байгууллагын ажилтан, алба хаагч, ахмадууд та бүхэндээ шинэ он, шинэ жилийн баярын мэнд хүргэе.

Улиран одож буй 2019 он та бидний хувьд ололт амжилт, дэвшил бүтээлээр дүүрэн байж, хуулиар хүлээсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилтоо амжилттай биелүүлэн шинэ онтойгоо золгож байгааг тэмдэглэхэд таатай байна.

Ирэх 2020 онд прокурор, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, прокурорын бие даасан хараат бус байдлыг хангах, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдэхэд та бид хамтран ажиллах болно.

Прокурорын байгууллагын нэр хүндтэй, хариуцлагатай албыг хашиж буй прокурор, ажилтнууд болон ахмадууд Та бүхний гэр бүлд шинэ оны мэндчилгээ дэвшүүлж, ажлын амжилт, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Та бүхэн сайхан баярлаарай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ
ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ

Банзрагчийн ЖАРГАЛСАЙХАН

2019 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2950